

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/5/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа.....	16
4.2 Төлбөрийн акт.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/123

БАЯНХОНГОР СУМЫН ЭРДЭМ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.ЗАГДСҮМ ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Сонины үнэ, хогны төлбөр, санхүүгийн программын лицензийн төлбөр, гар утасны дугаар зэрэг шууд зардлыг бараа материалд орлогоор бүртгэсэн,
- Төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материалыг акталсан, материалыг устгал хийсэн актыг үйлдээгүй,
- Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулаагүй,
- Тайлант онд бэлтгэсэн бараа материалыг нэр төрлөөр нь бүртгээгүй,

• 005020549

- Өмнөх жилийн аудитаар байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлэх зөвлөмжийг өгсөн байхад 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор ном, сурах бичгийг бүрэн тоолоогүй байна.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь “худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Үнэлгээ”, “Үнэн зөв байдал” зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,383,238.83</u>	<u>180,996,452.05</u>
АВЛАГА	00.00	421,513.22
Бусад авлага	00.00	421,513.22
Байгууллагаас авах авлага	00.00	421,513.22
БАРАА МАТЕРИАЛ	81,503,238.83	87,694,938.83
Түүхий эд материал	51,774,709.83	53,849,409.83
Тусгай зориулалттай материал	48,168,909.83	49,279,409.83
Эм боох материал	3,605,800.00	4,570,000.00
Хангамжийн материал	29,728,529.00	33,845,529.00
Бичиг хэргийн материал	687,000.00	635,000.00
Аж ахуйн материал	1,930,809.00	3,255,809.00
Бусад хангамжийн материал	27,110,720.00	29,954,720.00
НӨӨЦИЙН БАРАА	92,880,000.00	92,880,000.00
Бусад нөөц	92,880,000.00	92,880,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,345,819,844.22</u>	<u>2,333,888,284.19</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,345,819,844.22	2,333,888,284.19
Биет хөрөнгө	1,977,569,844.22	1,958,418,284.19
Барилга, байгууламж, орон сууц	1,977,043,408.24	1,977,043,408.24
Хуримтлагдсан элэгдэл	-93,599,105.80	-139,383,712.72
Машин тоног төхөөрөмж (компьютер)	300,521,090.25	348,374,790.25
Хуримтлагдсан элэгдэл	-249,065,211.64	-261,503,686.51
Тавилга, аж ахуйн эд хогшил	163,701,761.73	164,567,761.73
Хуримтлагдсан элэгдэл	-121,920,581.12	-130,875,009.36
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	194,732.56	194,732.56
Бусад үндсэн хөрөнгө	20,259,486.00	20,259,486.00
Хуримтлагдсан элэгдэл	-19,565,736.00	-20,259,486.00
Биет бус хөрөнгө	368,250,000.00	375,470,000.00
Програм хангамж	1,719,860.00	8,939,860.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,719,860.00	-1,719,860.00
Бусад биет бус хөрөнгө	368,250,000.00	368,250,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,520,203,083.05</u>	<u>2,514,884,736.24</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>277,030.00</u>	<u>00.00</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	277,030.00	00.00
Өглөг	277,030.00	00.00
Ажилчидтай холбогдсон өглөг	264,630.00	00.00
Бусад өглөг	12,400.00	00.00
Байгууллагад төлөх өглөг	12,400.00	00.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,519,926,053.05</u>	<u>2,514,884,736.24</u>
Засгийн газрын хувь оролцоо	2,519,926,053.05	2,514,884,736.24
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,627,034,865.06	1,627,034,865.06
Өмч: - төрийн	1,627,034,865.06	1,627,034,865.06
Хуримтлагдсан үр дүн	-7,122,751.79	-12,164,068.60
Өмнөх үеийн үр дүн	-7,122,751.79	-7,122,751.79
Тайлант үеийн үр дүн	00.00	-5,041,316.81
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,013,939.78	900,013,939.78
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,520,203,083.05</u>	<u>2,514,884,736.24</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,083,175,334.00	1,863,500,092.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,167,246.00	2,810,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	95,167,246.00	2,810,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,167,246.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,717,246.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/		1,000,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/		1,810,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,988,008,088.00	1,860,690,092.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,701,489,300.00	1,550,858,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,701,489,300.00	1,550,858,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,272,688.00	107,342,238.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,062,888.00	107,342,238.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,209,800.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,246,100.00	202,489,054.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,246,100.00	202,489,054.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,954,839,700.01	1,868,541,408.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,954,839,700.01	1,868,541,408.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,719,540,520.01	1,729,690,445.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,232,154,378.50	1,248,856,545.78
210101	Үндсэн цалин	909,334,751.50	991,192,063.78
210102	Нэмэгдэл	178,947,469.00	176,066,087.00
210104	Урамшуулал	143,872,158.00	81,598,395.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,710,762.24	159,646,017.00
210201	Тэтгэврийн даатгал	107,522,962.00	115,215,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,278,700.00	11,113,619.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,252,600.00	8,791,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563,300.00	2,198,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,093,200.24	22,326,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,286,599.00	201,490,754.00
210301	Гэрэл, цахилгаан	4,059,101.00	4,889,095.00
210302	Түлш, халаалт	176,181,750.00	174,569,243.00
210303	Цэвэр, бохир ус	22,045,748.00	22,032,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,849,233.00	19,179,389.00
210401	Бичиг хэрэг	3,428,200.00	8,181,420.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,537,033.00	2,840,469.00
210404	Ном, хэвлэл	172,500.00	67,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,511,600.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,299,900.00	1,919,200.00

**Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,605,800.00
2105	Нормативт зардал	6,395,950.00	1,902,350.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,395,950.00	1,902,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,951,800.00	8,555,300.00
210604	Урсгал засвар	5,951,800.00	8,555,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,540,000.00	522,000.00
210702	Дотоод албан томилолт	1,540,000.00	522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,416,800.00	3,559,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,816,800.00	2,734,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,234,997.27	85,979,090.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,084,915.00	14,572,630.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,111,420.00	2,400,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	93,038,662.27	69,005,560.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	235,299,180.00	138,850,963.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,754,188.00	128,878,238.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,546,300.00	34,242,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,811,368.00	47,714,368.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,251,520.00	46,271,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,145,000.00	650,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,022,501.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,959,501.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,522,491.00	9,972,725.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,522,491.00	9,972,725.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	128,335,633.99	-5,041,316.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	128,335,633.99	-5,041,316.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-135,458,385.78	2,391,590,419.06
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-135,458,385.78	2,391,590,419.06
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	128,335,633.99	128,335,633.99
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-7,122,751.79	2,519,926,053.05
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-7,122,751.79	2,519,926,053.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-7,122,751.79	2,519,926,053.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,041,316.81	-5,041,316.81
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,627,034,865.06	900,013,939.78	-12,164,068.60	2,514,884,736.24

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,988,458,088.00	1,860,690,092.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	450,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	450,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	450,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,988,008,088.00	1,860,690,092.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,701,489,300.00	1,550,858,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,272,688.00	107,342,238.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,062,888.00	107,342,238.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,209,800.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	208,246,100.00	202,489,054.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	208,246,100.00	202,489,054.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,966,157,088.00	1,804,616,092.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,966,157,088.00	1,804,616,092.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,730,618,708.00	1,665,101,129.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,232,168,229.00	1,248,778,689.00
210101	Үндсэн цалин	909,348,602.80	991,114,207.00
210102	Нэмэгдэл	178,947,468.20	176,066,087.00
210104	Урамшуулал	143,872,158.00	81,598,395.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,710,762.00	159,646,017.00
210201	Тэтгэврийн даатгал	107,522,962.00	115,215,998.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,278,700.00	11,113,619.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,252,600.00	8,791,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	563,300.00	2,198,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,093,200.00	22,326,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	202,286,599.00	201,490,754.00
210301	Гэрэл, цахилгаан	4,059,101.00	4,889,095.00
210302	Түлш, халаалт	176,181,750.00	174,569,243.00
210303	Цэвэр, бохир ус	22,045,748.00	22,032,416.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,797,233.00	17,455,089.00
210401	Бичиг хэрэг	3,532,200.00	8,147,020.00
210402	Тээвэр, шатахуун	1,900,000.00	1,980,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,537,033.00	2,840,469.00
210404	Ном, хэвлэл	5,192,500.00	1,178,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,511,600.00	585,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,123,900.00	2,724,600.00
2105	Нормативт зардал	9,513,950.00	4,489,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,395,950.00	2,627,500.00

**Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,118,000.00	1,862,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	98,960,800.00	8,555,300.00
210604	Урсгал засвар	98,960,800.00	8,555,300.00
2107	Томилолт, зочны зардал	1,540,000.00	622,000.00
210702	Дотоод албан томилолт	1,540,000.00	622,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,587,300.00	4,693,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,987,300.00	3,868,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,053,835.00	19,370,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,998,415.00	16,987,480.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,055,420.00	2,383,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	235,538,380.00	139,514,963.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,993,388.00	129,542,238.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,785,500.00	34,242,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,811,368.00	47,714,368.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,251,520.00	46,271,870.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,145,000.00	1,314,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,022,501.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,959,501.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	124,522,491.00	9,972,725.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,522,491.00	9,972,725.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,301,000.00	56,074,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,301,000.00	56,074,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,301,000.00	56,074,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,301,000.00	56,074,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,301,000.00	56,074,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-22,301,000.00	-56,074,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,772,893,800.00	1,743,375,129.00	29,518,671.00	98.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,772,893,800.00	1,743,375,129.00	29,518,671.00	98.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,735,338,600.00	1,707,819,129.00	27,519,471.00	98.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,750,200.00	1,248,778,689.00	4,971,511.00	99.60
210101	Үндсэн цалин	996,085,000.00	991,114,207.00	4,970,793.00	99.50
210102	Нэмэгдэл	176,066,100.00	176,066,087.00	13.00	100.00
210104	Урамшуулал	81,599,100.00	81,598,395.00	705.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,871,100.00	159,646,017.00	225,083.00	99.86
210201	Тэтгэврийн даатгал	115,216,100.00	115,215,998.00	102.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,163,700.00	11,113,619.00	50,081.00	99.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,931,000.00	8,791,700.00	139,300.00	98.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,232,700.00	2,198,000.00	34,700.00	98.45
210205	Эрүүл мэндийн даатгал	22,327,600.00	22,326,700.00	900.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,035,000.00	201,490,754.00	19,544,246.00	91.16
210301	Гэрэл, цахилгаан	5,505,200.00	4,889,095.00	616,105.00	88.81
210302	Түлш, халаалт	192,215,800.00	174,569,243.00	17,646,557.00	90.82
210303	Цэвэр, бохир ус	23,314,000.00	22,032,416.00	1,281,584.00	94.50
2104	Хангамж, бараа материалын зардал	18,511,000.00	17,455,089.00	1,055,911.00	94.30
210401	Бичиг хэрэг	5,526,500.00	8,147,020.00	-2,620,520.00	147.42
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,980,000.00	20,000.00	99.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,094,200.00	2,840,469.00	2,253,731.00	55.76
210404	Ном, хэвлэл	1,749,700.00	1,178,000.00	571,700.00	67.33
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,600,000.00	585,000.00	1,015,000.00	36.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,540,600.00	2,724,600.00	-184,000.00	107.24
2105	Нормативт зардал	5,739,800.00	4,489,500.00	1,250,300.00	78.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,627,800.00	2,627,500.00	300.00	99.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,112,000.00	1,862,000.00	1,250,000.00	59.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,584,600.00	33,544,300.00	40,300.00	99.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,000,000.00	24,989,000.00	11,000.00	99.96
210604	Урсгал засвар	8,584,600.00	8,555,300.00	29,300.00	99.66
2107	Томилолт, зочны зардал	1,023,700.00	622,000.00	401,700.00	60.76
210702	Дотоод албан томилолт	1,023,700.00	622,000.00	401,700.00	60.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,439,400.00	2,423,000.00	16,400.00	99.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,599,400.00	1,598,000.00	1,400.00	99.91
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	225,000.00	15,000.00	93.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39383800.00	39369780.00	14,020.00	99.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,000,000.00	16,987,480.00	12,520.00	99.93

**Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,383,800.00	22,382,300.00	1,500.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37555200.00	35556000.00	1,999,200.00	94.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,555,200.00	35,556,000.00	1,999,200.00	94.68
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,239,800.00	34,242,000.00	1,997,800.00	94.49
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,315,400.00	1,314,000.00	1,400.00	99.89
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,772,893,800.00	1,743,375,129.00	29,518,671.00	98.34
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,550,858,800.00	1,540,886,075.00	9,972,725.00	99.36
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,550,858,800.00	1,540,886,075.00	9,972,725.00	99.36
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	222,035,000.00	202,489,054.00	19,545,946.00	91.20
132001	Орон нутгийн төсвөөс	222,035,000.00	202,489,054.00	19,545,946.00	91.20
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	102.00	99.00	3.00	97.06
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	85.00	84.00	1.00	98.82
620003	Үйлчлэх ажилтан	16.00	14.00	2.00	87.50
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,414.00	1,426.00	-12.00	100.85
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,414.00	1,426.00	-12.00	100.85
630001	Төрийн өмчит ЕБС	1,414.00	1,426.00	-12.00	100.85
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	102.00	100.00	2.00	98.04
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	81.00	79.00	2.00	97.53
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	21.00	21.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	78,146,688.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,146,688.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,083,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,083,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,083,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,062,888.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,062,888.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,811,368.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	41,251,520.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	78,128,687.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,128,687.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	77,044,887.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,083,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд эд хөрөнгийн тооллогыг бүрэн хийх, нягтлан бодох бүртгэлийг холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв хөтлөх, бараа материалын нэр төрлөөр нь бүртгэх, бараа материалд шууд зардлыг бүртгэхгүй байх, бараа материалыг өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрийн дагуу бүртгэлээс хасан устгалын актыг үйлдэж байх зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 14/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Загдсүм, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ч.Мэнд-Амар нар зурж, нярваар Б.Лхагва-Очир ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын Эрдэм сургууль 2021 оны 2020-2021 оны хичээлийн жилд 99 орон тоотой, нийт 1434 сурагчтайгаас бага ангид 743, дунд ангид 460, ахлах ангид 231 сурагчтайгаар 46 бүлэгтэй үйл ажиллагаа явуулж, Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нийт судлагдахууны дундаж оноо 513, аймгийн хэмжээнд элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноогоор 7 дугаар байранд шалгарсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллага нягтлан бодох бүртгэлийг 2018 онд баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу хөтөлсөн байна.

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,954,839.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,548.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,638.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,961,421.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,614.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 15,691.4 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,514.884.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 5,318.3 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,383.2	180,996.5	6,613.2
Авлага	-	421.5	421.5
Бараа материал	174,383.2	180,574.9	6,191.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,345,819.8	2,333,888.3	(11,931.6)
Үндсэн хөрөнгө	2,831,690.3	2,887,630.0	55,939.7
Хуримтлагдсан элэгдэл	(485,870.5)	(553,741.8)	(67,871.3)
Нийт хөрөнгө	2,520,203.1	2,514,884.7	(5,318.3)
Өр төлбөр	277.0	-	(277.0)

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,519,926.1	2,514,884.7	(5,041.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,520,203.1	2,514,884.7	(5,318.3)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эцэст хувь хүний орлогын албан татварын 421.5 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87,694.9 мянган төгрөг болж өмнөх оноос 86,688.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өөрийн хөрөнгөөр төсвийн хөрөнгөөр 49,609.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 1,810.0 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 136,015.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материал акталсан байна.

Оны эхэнд бүртгэлтэй 2,831,690.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж тайлант онд төсвийн хөрөнгөөр 44,988.0.0 мянга, Монгол улсын Засгийн газар болон Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас хэрэгжүүлсэн төслийн санхүүжилтээр 11,086.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, аймгийн Засаг даргын Тамгын газраас 1,000.0 мянган төгрөгийн зурагт хандиваар ирснийг бүртгэлд авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ний өдрийн 139 дүгээр тогтоолоор 1,134.3 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын дэргэдэх Насан туршийн боловсролын төвд шилжүүлснээр оны эцэст 2,887,630.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 97,921.33 мянган төгрөгөөр буурч 2,422,004.7 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор сумын Эрдэм сургууль 2021 оны төсвийн төлөвлөлтийг 2,071,183.2 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 1,644,977.5 мянган төгрөгөөр баталсныг оны эцэст 1,772,893.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Баянхонгор сумын Эрдэм сургууль өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр авахаар батлагдсан 1,550,858.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс авахаар батлагдсан 222,035.0 мянган төгрөгийн дэмжлэгээс 19,545.9 мянган төгрөгийг дутуу авч, нийт 1,753,347.9 мянган

төгрөгийн санхүүжилт авснаас 1,743,375.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 9,972.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 114,271.3 мянган төгрөгийн санхүүжилт орсноос албан хаагчдад тэтгэмжийг олгож, 756.0 мянган төгрөгийн санхүүжилтээр бичиг хэргийн материал худалдан авч, Монгол улсын Засгийн газар болон Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциациас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн 10,600.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 7,220.0 мянган төгрөгийн апплейкэшн хөгжүүлэх төлбөрийг “Бэст софт” ХХК-д төлж, 3,380.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр 2.0 сая төгрөгийн төслийг Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газарт бичиж шалгарч, тус санхүүжилтээс 674.0 мянган төгрөгийн вакум хаалт бэлтгэн, 460.0 мянган төгрөгөөр хөшиг, дэвсгэр, 866.0 мянган төгрөгөөр сэтгүүлийн ширээ сандал авсныг бүртгэлд бүрэн тусгажээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд үдийн цайны зардлын хэмнэлтээс хөрөнгө бэлтгэх зардалд зохицуулалт хийлгэн үдийн хоол болохтой холбоотой 19,994.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж бэлтгэн, сургалтын үйл ажиллагаанд ашиглах 37,080.0 мянган төгрөгийн техник, тоног төхөөрөмж бэлтгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Баянхонгор сумын Эрдэм сургууль гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд нийт 86 ажил арга хэмжээг төлөвлөн, 93.8%-иар биелүүлж ажилласан байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар

Илэрсэн алдаа зөрчлийн дүн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, бараа материалын тайланг нярав сараар гаргаагүй, өмнөх оны аудитаар Төсвийн тухай хуулийг мөрдөж, батлагдсан орон тоонд багтаан ажиллах зөвлөмжийг өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй, 2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан, цалингийн зардлын хэмнэлтийг урсгал засварын үйл ажиллагаанд зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.3 дахь заалт, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул дүгнэлтийг хязгаарлав.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 304,546.9 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс байгууллагын даргын 2021.10.19-ний өдрийн Б/18 дугаар тушаалыг мэдээлээгүй, 12 сарын санхүүжилтийг 2,393.0 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант онд бичиг хэргийн зардалд батлагдсан 5,526.5 мянган төгрөгийг 2,620.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулж, "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" заалтыг мөрдөж ажиллаагүй,
2. Байгууллагын тогтмол зардалд 221,035.0 мянган төгрөгийг төлөвлөн гүйцэтгэлээр батлагдсан төсвийн 91.1 хувь буюу 201,490.7 мянган төгрөг зарцуулсан нь дээрх тогтоолын 1.8 дахь "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн шалгуурт нийцээгүй байгаа тул менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, менежментийн захидлаар 6 зөвлөмж өгч, 1 албан шаардлагыг өгсөн байна. Шалгагдагч байгууллага 2021.06.30-ний өдрийн 78 дугаартай албан бичгээр төрийн аудитын байгууллагад зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх, шилэн дансны цахим хуудаст мэдээллийг бүрэн байршуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс өмнөх оны алдаа зөрчил аудитаар дахин илэрч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 188,047.6 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 7,220.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд үнийн дүнгүй албан шаардлага өгч, 180,827.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор сумын Эрдэм сургуулийн санхүүгийн тайланд нийт 92,880.0 мянган төгрөгийн залруулгыг хийлээ. Үүнд:

Тус сургуулийн 2020 оны санхүүгийн тайланд “Буян Аривжих Од” ХХК-ийн гүйцэтгэсэн сургуулийн гадна фасадын засварын ажлыг 92,880.0 мянган төгрөгийн гүйцэтгэлээр үнэлэн нөөцийн бараанд бүртгэсэн ба 2021 онд тус ажлыг улсын комисс хүлээн аваагүй байхад нягтлан бодогч нөөцийн бараанаас хасаж, тайлант жилийн зардлаар бүртгэсэн алдаа илэрсэн тул бараа материалд залруулга хийв.

4.2 Төлбөрийн акт

1. Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн, Эрдэм сургуулийн нягтлан бодогч, сургуулийн гал тогоог түрээслэгч “Тосуйн гол” ХХК-ийн захирал нар 2020.03.06-ний өдөр “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ” байгуулж, сард 350.0 мянган төгрөгийн түрээс төлөхөөр заажээ. Тус компани 2021 онд үдийн цай олгосон 3,10,11,12 саруудын түрээсийн төлбөрт 1,131.9 мянган төгрөгийг төлөөгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй, гэрээг дүгнээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг тусгана”, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн, Эрдэм сургуулийн нягтлан бодогч, сургуулийн гал тогоог түрээслэгч “Тосуйн гол” ХХК-ийн захирал нар 2020.03.06-ний өдөр “Орон нутгийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний 6.8 дахь “Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийн 1,131.9 мянган төгрөгийг “Тосуйн гол” ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Өмнөх жилийн аудитаар байгууллагын жилийн эцсийн тооллого, тооцоог бодитой, чанартай гүйцэтгэх, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хариуцлагыг дээшлүүлэх зөвлөмжийг өгсөн байхад 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор ном, сурах бичгийг бүрэн тоолоогүй, хөрөнгийг нийт үнийн дүнгээр тооцож гаргаагүй, тооллогыг иж бүрэн, чанартай гүйцэтгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх “Тооллогын комисс тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 52,396.0 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага ... цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр... мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан Монгол улсын Засгийн газар болон Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциациас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн 10,600.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 7,220.0 мянган төгрөгийн апплейкэшн хөгжүүлэх төлбөрийг “Бэст софт” ХХК-д шилжүүлсэн байна.

Тус апплейкэшнийг 2022.06.01-ний дотор бүрэн ашиглалтад оруулах гэрээг “Бэст софт” ХХК-тай байгуулж, апплейкэшн ашиглалтад ороогүй байхад санхүүгийн тайланд хөрөнгөд орлогоор бүртгэн, жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор үлдэгдлээр тоолсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд ... бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгохдоо авлагаар бүртгээгүй, нягтлан бодох бүртгэлд өглөгөөр бүртгэсэн байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 3.6 дахь заалтыг хэрэгжүүлж, цалингийн урьдчилгааг авлагын дансаар бүртгэх.

2. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

2.1. **Илрүүлэлт:** Байгууллагын өмч хамгаалах зөвлөл, төсвийн захирагчийн шийдвэргүйгээр 3,605.8 мянган төгрөгийн эм боох материалыг сургуулийн эмчийн шаардах хуудсаар зарлагадан, эмч н.Нацагдоржид хүлээлгэн өгсөн байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2022.02.21-ний өдрийн 6/278 дугаар албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, цаашид байгууллагын өмч хамгаалах зөвлөл, байгууллагын даргын шийдвэрийн дагуу эргэлтийн хөрөнгийг акталж, устгал хийсэн актыг тухай бүр хийж, санхүүгийн баримтад хавсаргах.

3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: "Өнөөгийн Баянхонгор" сонины үнэ, хогны болон санхүүгийн программын лицензийн төлбөр, гар утасны дугаар зэргийг бараа материалд орлогоор бүртгэн зарлагдсан байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.15-д заасан "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно" гэснийг мөрдөж ажиллах

4. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан 12.247.3 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн программд нэр төрлөөр бүртгээгүй, бөөн дүнгээр орлогод авсан байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Нийлүүлэгч байгууллагын зарлагын баримтыг үндэслэн бараа материалыг нэр төрлөөр нь бүртгэх.

5. Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Няравын бараа материалын тайланг санхүүгийн программын орлого, зарлагатай тулган шалгахад бараа материалын 5 дансны орлого, зарлагыг нийт 1,130.2 мянган төгрөгөөр зөрүүтэй гаргасан байгаа ба энэ нь нярав тухай бүр нь бараа материалын тайлан гаргадаггүй, нягтлан бодогч няравын бэлтгэсэн тайланг хүлээн авч хянан бүртгэлд тусгадаггүй зэрэгтэй холбоотой байна.

5.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг мөрдөж бараа материалын тайланг сар бүр бэлтгэх, бараа материалын тайланг хянаж баталгаажуулан бүртгэлд тусгаж, бүртгэлийн ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын Эрдэм сургууль	10	177,428.7	1	92,880.00	1	1,131.90	3	59,616.0	5	23,800.8

---oOo---